

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн
хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 09 сарын 25-ны өдрийн 1/18 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа 2017 оны 09 сарын 26-ны өдрөөс ажлын 5 хоногт багтаан шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Эрүүл мэндийн төвийн 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Сэлэнгэ сумын 5-р багт байрлах Эрүүл мэндийн төв нь сумын иргэд албан хаагчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилготой.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2016 оны 01 дугаар сарын 11-ний өдрийн А/01 дугаар тушаалын 1 дугаар хавсралтаар эрхлэгч эмч, их эмч 2, багийн эмч 3, уламжлалын бага эмч, эх баригч, статистикч эмч, лаборант, ахлах сувилагч, жолооч, тогооч, ариутгагч сувилагч, сувилагч 4, үйлчлэгч 4, галч 4 нийт тоотой ажилласан байна.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл Ж.Сэргэлэн, 2-р гарын үсгийг 2016 оны 01

сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал П.Бэрцэцэг нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040920001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 040920401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл тайланг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад байгууллагуудаас шалгалт ороогүй, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн тул итгэмжлэл олгосон.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Эрүүл мэндийн төвийн 2016 оны касс харилцах, цалингийн баримт, эрхлэгчийн тушаал, бараа материалын баримт, 2016 оны санхүүгийн тайлан, 2016 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт зэрэг материалуудад тулгуурлан эрхлэгч Ж.Сэргэлэн, нягтлан бодогч П.Бэрцэцэг, нярав М.Эрдэнэчимэг нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2016 онд улсын төсвөөс 301204.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, үйл ажиллагааны орлогоос 1255.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 3049.2 мянган төгрөг бүгд 305509.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2016 онд төсөвт зардлыг 326201.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсдын цалинд 188913.0 мянган төгрөг, тогтмол зардалд 22713.6 мянган төгрөг, нормативт зардалд 27503.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16316.3 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 1344.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 1047.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 502.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 7198.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 3049.2 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэлийн үндсэн 040920001 дугаар данснаас үлдэгдэл 4670.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт орлого, санхүүжилтийн талаар: 2016 онд нэмэлт санхүүжилтийн дансаар шинжилгээний орлогоос 937.1 мянган төгрөг, аймгийн ЭМГ-аас шатахууны үнэ 306.8 мянган төгрөг орж ирснийг Пролианс ХХК-д оношлуурын төлбөрт 1243.9 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Цалин урамшууллын талаар: Их эмч Сэргэлэн нь 2015 оны үр дүнгийн гэрээгээ В үнэлгээтэй дүгнүүлсэн тул сумын Засаг даргын 2016 оны 01 сарын 22-ны өдрийн А/18 дугаар захирамжаар 0.5 сарын цалин 317.4 мянган төгрөгөөр, Аймгийн ЭМГ-ын даргын 2016 оны 03 сарын 31-ний өдрийн А/15 дугаар тушаалаар “Оны шилдэг байгууллагаар” шалгарсан байгууллагын дарга эрхлэгч нарыг 1 сарын үндсэн цалин 634.9 мянган төгрөг, сумын Засаг даргын 2016 оны 10 сарын 26-ны өдрийн А/121 дүгээр захирамжаар хөдөө

орон нутагт тогтвор суурьшилтай ажилсан их эмчийг 4 дэх жилээс нь жил бүр 1 сарын үндсэн цалин олгохоор 634.9 мянган төгрөг, мөн 2016 оны 12 сарын 06-ны өдрийн А/159 дүгээр захирамжаар 1 сарын үндсэн цалин 742.9 мянган төгрөгөөр, 2016 оны 12 сарын 20-ны өдрийн Б/53 дугаар тушаалаар тогоочийг 1 сарын үндсэн цалин 408.0 мянган төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан байна.

ЭМТ-ийн даргын 2016 оны 12 сарын 14-ний өдрийн 49 дугаар тушаалаар 4 галчид 20%-иар ур чадварын нэмэгдэл, 2016 оны 12 сарын 20-ны өдрийн 51 дүгээр тушаалаар 16 ажилтанд 25%-иар ур чадварын нэмэгдэл тус бүр олгосон байна.

ЭМТ-ийн даргын 2016 оны 04 сарын 18-ны өдрийн Б/15 дугаар тушаалаар 23 ажилтанд 150.0-280.0 мянган төгрөгийн нийт 4680.0 мянган төгрөг, 2016 оны 07 сарын 18-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар 21 ажилтанд 15-45%-иар 3598.0 мянган төгрөг, 2016 оны 10 сарын 21-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар 21 ажилтанд 20-45%-иар 3598.0 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 15-ны өдрийн Б/50 дугаар тушаалаар 19 ажилтанд 20-45%-иар 3598.0 мянган төгрөгийн тус бүр үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

| № | Нэр | Мөнгөн дүн /төгрөгөөр/ | | | |
|---|------------------------|------------------------|-------------|---------|-----------------|
| | | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Эцсийн үлдэгдэл |
| 1 | Барилга байгууламж | 293476153 | | | 293476153 |
| 2 | Авто тээврийн хэрэгсэл | 28103998 | 10233900 | | 38337898 |
| 3 | Машин тоног төхөөрөмж | 80284542.22 | 3936789.93 | | 84221332.15 |
| 4 | Тавилга, эд хогшил | 14134875.70 | 1988600 | | 16123475.70 |
| 5 | Номын фонд | 187550 | | | 187550 |
| | Дүн | 416187118.92 | 16159289.93 | | 432346408.85 |

2016 оны эхэнд 416187.1 мянган төгрөг хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 2 ш сандал 250.9 мянган төгрөг, 3 ш ширээ 897.9 мянган төгрөг, 2 ш шкаф 839.8 мянган төгрөг нийт 1988.6 мянган төгрөгийн эд хогшил худалдан авч, Япон улсын тусламжаар 10233.9 мянган төгрөгийн түргэн тусламж үйлчилгээний автомашин, Эрүүл мэндийн яамны хандиваар 2136.7 мянган төгрөгийн нөөтбүүк, УВЧ тоног төхөөрөмжийг орлогодон нийт 432346.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

| № | Тайлангийн нэр | Мөнгөн дүн /төгрөгөөр/ | | | |
|---|------------------|------------------------|---------|---------|-----------------|
| | | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Эцсийн үлдэгдэл |
| 1 | Хүнсний материал | 2490051 | 5240000 | 4954390 | 2775661 |
| 2 | Бичиг хэрэг | | 959250 | 959250 | |

| | | | | | |
|---|----------------------|-------------|----------|-------------|-------------|
| 3 | Аж ахуйн материал | 4447700 | 2570000 | 279500 | 6738200 |
| 4 | Бусад хангамжийн мат | 13136392.50 | | 4381685.50 | 8754707 |
| 5 | Эм боох материал | 5779710 | 19693838 | 21793060.20 | 3680487.80 |
| 6 | Сэлбэг хэрэгсэл | | 452000 | 452000 | |
| 7 | Барилгын засвар | | 892000 | 892000 | |
| 8 | Түлш шатах тослох | | 18726100 | 12398500 | 6327600 |
| 9 | Мал амьтад | 994000 | 414000 | 618000 | 790000 |
| | НИЙТ ДҮН | 26847853.50 | 48947188 | 46728385.70 | 29066655.80 |

6.4. Өглөг, авлагын талаар: 2016 оны эхэнд 368.5 мянган төгрөгийн түлш халаалтын 368.5 мянган төгрөгийн өглөгийг бууруулж оны эцэст өглөггүй, авлагагүй тайлан баланс гарсан байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд нийт 149 мэдээлэл оруулахаас 2016 онд 90 мэдээллийг хугацаанд нь, 59-ийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан. Няравын тайлан нь эмх цэгцтэй үдэж архивлагдсан.

НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Шалгалтаар Эрүүл мэндийн төвийн их эмч Ж.Сэргэлэн нь эрхлэгчийн ажлыг хавсран ажиллахдаа даргын цалин 742153 төгрөгөөс 40%-иар тооцох байтал эмчийн цалин 634912 төгрөгөөс 40%-иар тооцож 2016 оны 1 дүгээр сараас 5 сар хүртэл 5 сарын хугацаанд олгосон нь-олговол зохих=зөрүү/1269825-1484305=(214480)/ төгрөг дутуу, мөн 2016 оны 07 сараас 12 сар хүртэл захирамж шийдвэргүйгээр эрхлэгчийн цалин 742153 төгрөгөөр цалинжиж 2016 оны 1 дүгээр сараас 12 сар хүртэл олгосон нь-олговол зохих=зөрүү /3409206-2913567=495639/ төгрөг илүү олгосны зөрүү 281159 төгрөгийг илүү, сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 06-ны Б/159 дугаар захирамжаар Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан 2003 оны 233/141/310 тоот тушаалаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын цалин 742919 төгрөгийн урамшууллыг 2 дох удаа олгосон.

2. Нярав үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тайлан гаргадаггүй, нягтлан бодогч санхүүгийн программ дээр шивдэг, оны эцэст эд хөрөнгийн тооллого хийж баримтжуулсан.

3. Эрүүл мэндийн төвийн ариутгагч сувилагч М.Эрдэнэчимэг нь няравын ажлыг хавсран ажиллахдаа няравын цалин 437825 төгрөгөөс 40%-иар тооцох байтал сувилагчийн цалин 469799 төгрөгөөс 40%-иар тооцож 2016 оны 1-4 дүгээр сар, 10-12

дугаар сар хүртэл 7 сарын хугацаанд олгосон нь-олговол зохих=зөрүү/1301706-1225910=75796/ төгрөг илүү, мөн үйлчлэгч Д.Туул нь 2016 оны 5-9 сар хүртэл 5 сарын хугацаанд няравын ажлыг хавсаран ажиллахдаа үйлчлэгчийн цалин 433561 төгрөгөөс 40%-иар цалинжиж 2016 оны 5 дүгээр сараас 9 сар хүртэл олгосон нь-олговол зохих=зөрүү /867120-875650=(8530)/ төгрөг дутуу олгосон.

4. Орон нутгийн байгууллагуудын нягтлан бодогч нь ажил үүргийн хуваариар Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг байхад 1-4 дүгээр улиралд үр дүнгийн урамшуулалт цалин нийт 529932 төгрөгийг нягтлан бодогч П.Бэрцэцэгт олгосон.

5. 2016 оны 08 сарын 12-ны өдөр Д.Туулын ХААН банкны 5280020393 тоот дансанд дотоод журмаар 310.0 мянган төгрөгийг эрх захирагчийн шийдвэргүйгээр олгосон нь ажилчдын цалингаас суутгасан суутгалыг няравын дансанд хийсэн байна.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 2 актаар 366.3 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 4 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй, мөн шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт сул байна дүгнэлээ.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, актын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА